

ОНЦЛОХ СЭДЭВ

**БОАЖЯ-НЫХАН “ГАНГА”
НУУРЫГ СЭРГЭЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ
БОЛОВСРУУЛЖЭЭ**

II нүүрт

ОНЦЛОХ ХУУДАС

ИПОТЕКИЙН ЗЭЭЛ ЗОГСОХГҮЙ...

V нүүрт

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР



Дугаарын **60** мөр

ХААЛТАЙ ХУРАЛДАНААС

Урамшуулал,
хариуцлагыг давхар
хэрэгжүүлбэ

Ж.МӨНХБАТ: БҮХ ТӨРЛИЙН ТАТВАРЫГ НЭМЭХГҮЙ



Гэрэл зургийг Г.АГУУЖИН

цилиндрийн багтаамж 4500-аас дээш бол татвар авах, 20 сая төгрөгөөс дээш хадгаламжтай иргэдийн хадгаламжийн хүүгээс татвар авах зэрэг найман төрлийн татварыг нэмэгдүүлэхээр тусгаад байсан юм. Тэгвэл энэхүү татваруудаас нэгийг нь ч нэмэхгүй байхаар МАН-ын бүлэг зөвшилцжээ. Мэдээлэл хийх үеэр ЗГХЭГ-ын дарга Ж.Мөнхбат “Засгийн газар 2016 оны улсын төсвийн тодотголыг УИХ-д өргөн барьсан. Төсвийн тодотголд тусгасан зарим асуудлыг МАН-ын бүлэг авч хэлэлцээд татвар нэмэх асуудлыг эргүүлэн татуулах улс төрийн шийдвэр гаргалаа. Төсвийн тодотголоор дамжуулж хэд хэдэн татварын зүйл заалтад өөрчлөлт оруулахаар төлөвлөж байсан. Тухайлбал, үл хөдлөх хөрөнгө, архи тамхи, алттай холбоотой татвар нэмэх асуудал оруулж ирээд байсан. Эцэст нь бүх төрлийн татварыг нэмэхгүй байх улс төрийн шийдвэр гаргалаа. Ерөнхийдөө зарим төрлийн татвар нэмэгдүүлэхтэй холбоотой ташаа ойлголт нийгэмд нэлээд цагадсан. Тухайлбал, 2.5 саяас дээш цалинтай иргэдэд тодорхой хэмжээний татвар ногдуулах санал гаргасан.

Үргэлжлэл нь II нүүрт

II ТӨГС

Рио-2016 зуны Олимпын 31 дүгээр наадам өндөрлөд цөөнгүй хоног өнгөрч байгаа ч хэл ам нь одоо болтол тасраагүй л байна. Чөлөөт бөхийн холбооныхон хоёр дасгалжуулагч руугаа хамаг хатуугаа чулуудаж, Дэлхийн бөхийн нэгдсэн холбооны өмнө толгой бөхийж, луйврыг нь хүлээн зөвшөөрөхөөс эхлээд юу эс өрнөх билээ. Тэгвэл олимпын үеэр иргэдийн хамгийн ярьж, бичсэн зүйл бол хариуцлагын тухай. Манай тамирчид ямар ч хариуцлагагүй байна. Зүгээр зогсч байгаад ялагдлаа, хариуцлага тооцох хэрэгтэй гэж олон хүн бухимдсан. Үүнийг бид зүгээр нэг бухимдал гэж хүлээж аваад, тамирчдаа өмөөрөд өнгөрөх биш хариуцлагын тогтолцоог бий болгох цаг болж. Дэлхийн их гүрнүүд, тухайлбал, Хятад, АНУ, Орос, Франц гээд цөөнгүй улс бүх л спортод анхаарлаа хандуулж, жигд хөгжүүлж байгаа.

Үргэлжлэл нь III нүүрт

Э.ТУУЛ

ЗГХЭГ-ын дарга Ж.Мөнхбат мэдээлэл хийлээ. Тэрбээр 2016 оны төсвийн тодотголын төсөлд тусгасан татвартай холбоотой бүх заалтыг Засгийн газар буцаан

татахаар болсон талаар мэдээлсэн юм. Шалтгаан нь УИХ дахь МАН-ын бүлгийн улс төрийн шийдвэрээс үүдэлтэй хэмээн ЗГХЭГ-ын дарга Ж.Мөнхбат мэдээлэлдээ онцолсон. Засгийн газраас боловсруулан оруулж ирсэн Төсвийн тодотголын тухай

хуульд хувь хүний орлогын албан татварыг хоёр шатлалтай болгох, нийгмийн даатгалын шимтгэлийг нэмэх, архи тамхины онцгой албан татварыг нэмэх, үл хөдлөх хөрөнгийн татвар буюу 150 ам метрээс дээш байрнаас татвар авах, автомашины

ҮЗЭЛ БОДОЛ

**АЛТЧИН
ТЭРБУМТНУУД**



& САМАРЧИН АРД ТҮМЭН

Н.ПУНЦАГБОЛД

Мөнгөөр дутахын зовлон үзээгүй, ард түмэн яаж амьдарч байгааг мэдэхгүй, тансаглалын заагийг хаагуур татахаа ч мэдэхгүй хэдэн хүнийг төрд сонгосныхоо горьг бид яс махандаа тултал амсч байна. Өөрсдийнхөө тансаглалыг танахаа мэдэхгүй байж ард түмнийхээ халаас руу хэв нэг гараа дүрэх төрийн түшээд одоо бүр байгалийн баялгаа хүртэл иргэдээс харамлаж байна. Яг

үгэндээ энгийн иргэд энэ эх орны байгалийн баялгаас юуг нь хүртэж байгаа юм. Хуруу хумсаа хуйхалж байж алтны үртэс түүнэ, тэгэхээр “нинжа” гэж ад үзнэ, янз бүрийн хууль журам, дүрэм ярина.

Үргэлжлэл нь III нүүрт

Би МОНГОЛОО
ингэж хөгжүүлнэ

Ж.БАТЖАРГАЛ: ХҮНСНИЙ САЛБАРЫН МӨНГӨНИЙ УРСГАЛЫГ АЙМАГ РУУГАА ТАТНА

Ж.ОТГОН

Төв аймгийн Засаг дарга
Ж.Батжаргалтай цаг үеийн
сэдвээр ярилцлаа.

Төв аймгийн хэмжээнд зуншлага сайхан болов уу. Одоо хадлан, тэжээл бэлтгэх ажил ид өрнөж байгаа байх?

Төв аймгийн хэмжээнд зуншлага ерөнхийдээ гайгүй байлаа. Одоогийн байдлаар бэлчээрийн ургамлын гарц бас тийм их сайн биш байна. Учир

нь орон нутагт буюу хадлан бэлтгэдэг гол бүс нутгуудад хадлан бэлтгэх талбай багавтар байгаа хэдий ч хадлан, тэжээл бэлтгэх асуудлыг малчид, иргэдтэйгээ зөвшилцөөд орон нутгаасаа бэлтгэхээр болсон. Харин тодорхой аж ахуйн зохион байгуулалтаар салаа болоод гардаг аж ахуйн нэгж, байгууллагууддаа бол зэргэлдээх аймгуудын ургамлын гарц гайгүй байгаа бус нутгууд руу хадлан бэлтгүүлэх чиглэлээр ажиллаж байна.

Танай аймаг Улаанбаатар хотыг хүнсний ногоогоор хангадаг шүү дээ. Энэ жил ургац хэр байх шиг байна вэ?

Энэ жилийн хувьд манай аймаг нийт дүнгээрээ 100 гаруй мянган га талбайд тариалалт хийсэн. Түүнээсээ 80 гаруй мянган га нь үр тарианы чиглэлээр үлдсэн талбайд нь төмс, хүнсний ногоо, малын тэжээл болон тосны ургамлын чиглэлээр тариалалт хийгдсэн.

Үргэлжлэл нь IV нүүрээс

ALBAN ESCOOP PC mall-д ИРЛЭЭ

ХААН Банк

	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2200.00	2228.00	ФУНТ	2885.00
ЕВРО	2431.00	2503.00	РУБЛЬ	32.70
ИЕН	21.05	21.70	ЮАНЬ	328.80

Хугалгаа хөгжлийн банк

	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2200.00	2233.00	ФУНТ	2885.00
ЕВРО	2416.00	2511.00	РУБЛЬ	32.72
ИЕН	20.92	21.80	ЮАНЬ	326.00

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

ОНЦЛОХ СЭДЭВ

БОАЖЯ-НЫХАН “ГАНГА” НУУРЫГ СЭРГЭЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛЖЭЭ



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Н.БАТЗАЯА

БОАЖ-ын сайд Д.Оюунхорол тэргүүтэй УУЯ, МХЕГ, УИХ-ын гишүүд, орон нутгийн холбогдох албаныхны хамтарсан баг Архангай аймгийн Цэнхэр сумын нутаг Орхон голын эхэнд өнгөрсөн амралтын өдрүүдэд ажиллаад ирсэн билээ. Үүнтэй холбогдуулан өчигдөр БОАЖ-ын сайд Д.Оюунхорол хэвлэлийн бага хурал хийсэн юм. Хэвлэлийн бага хурлын үеэр Орхон гол болон Ганга нуурын тулгамдаж

буй асуудлын талаар мэдээлэл өгсөн. Тодруулбал, Орхон голын эхэнд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшин, олборлолт явуулж буй “Монгол газар”, БМНС, “Алтай гоулд”, “Алтан дорнод” зэрэг компанийн тусгай зөвшөөрөл бүхий талбай дээр хийгдэж буй ажил, газрын эвдрэл, гол усны бохирдолтын байдалтай газар дээр нь танилцаж, тэдгээр аж ахуйн нэгжийнхэн болон нутгийн ард иргэдийн санал бодлыг сонсож, тодорхой шийдвэр гаргажээ. Мөн найман

аймгийн 53 сумын нутгийг дайран өнгөрдөг Орхон голын эхэнд уул уурхайн үйлдвэрлэл явуулж буй аж ахуйн нэгжүүд хууль дүрмийг биелүүлэлгүй, хариуцлагагүй уул уурхайн үйлдвэрлэл явуулсан нь гол ус бохирдох шалтгаан болжээ. Үүнээс гадна ширгэж алга болж буй “Ганга” нуурын талаар мэдээлэл өгсөн юм. Тус нуурын ус сүүлийн нэг сард огцом татарсны улмаас нуурын сайр хатаж, сул цагаан шороо босох болсон байна. Мөн энэ зуны долоо, наймдугаар сард агаарын

температур олон жилийн дунджаас 1-10 хүртэл хэмээр өсч, олон жилийн дундаж хур тунадасны хэмжээний дөнгөж 20 орчим хувь нь орсон нь нуур ширгэх гол шалтгаан болжээ. Одоогийн байдлаар “Ганга” нуурын ойр орчимд байрлах 37 орхийн 31 орчим мянган мал Ганга нуур, Оргихын булаг, Баян булгийн уснаас ундаалж байна. Түүнчлэн “Ганга” нуур орчимд гол төлөв хаврын улиралд нэлээд газрыг хамарсан хүчтэй хуй салхи салхилдаг. Хуй салхины улмаас нуурын ёроолыг элс дарж,

усны татралтад мөн нөлөөлж байгаа аж. Тиймээс БОАЖЯ-наас “Ганга” нуурын эко системийг хамгаалах, сэргээх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж эхэлжээ. Энэ дагуу Сүхбаатар аймгийн Байгаль орчны газраас хариуцан “Ганга” нуурыг хашиж хамгаалах хашаа барьж эхэлсэн байна. Мөн БОАЖЯ-наас “Ганга” нуурыг тэтгэх найдвартай эх үүсвэрийг судлах, үүлэнд зориудаар нөлөөлж хур тунадас оруулах зэрэг асуудлыг судалж, шийдвэрлэхээр болжээ.

ХААЛТТАЙ ХУРАЛДААНААС

Ж.МӨНХБАТ: БҮХ ТӨРЛИЙН ТАТВАРЫГ НЭМЭХГҮЙ

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Монгол Улсад цалин авч байгаа нийт иргэдийн 1.6 хувь нь 2.5 саяас дээш цалинтай байгаа гэсэн судалгаа бий. Үл хөдлөх хөрөнгөтэй холбоотойгоор 150-иас илүү гарсан метр квадрат татвар ногдуулахаар заасан. 150 метр квадрат хүртэлх байртай иргэд энэ татварт хамаарахгүй байсан. Мөн том оврын автомашины татвар гэхэд зөвхөн хилээр оруулж ирэх машинд л ногдуулах, одоо явж байгаа ороод ирчихсэн машинуудад огт хамаарахгүй байсан. Засгийн газар анхнаасаа нийгмээ, иргэдээ сонсч ажиллаж

байгаа. Тийм учраас УИХ-д 65 суудалтай гэхгүйгээр энэ удаа ч бас нийгмээ сонсч улс төрийн шийдвэрийг хүндэтгэж байна. Өөрөөр хэлбэл, суудлын олноор хүч түрж асуудлыг шийддэг алдааг давтахгүй байх нь чухал. Өнгөрсөн дөрвөн жилд Монгол Улсын төсвийн сахилга бат алдагдсан. Монгол Улс дөрөв, таван төсөвтэй болсон. Ингэж төсвийн сахилга бат алдагдсанаар төсөв хэт данхайх, алдагдал газар авах нөхцөл байдал үүссэн. Өнөөдөр Монголын төсвийн алдагдал дөрвөн их наяд буюу түүхэндээ байгаагүй өндөр хэмжээнд хүрсэн. Ер нь өнгөрсөн дөрвөн жил төсвийн сахилга бат алдагдсан гэдгийг та бүхэн мэдэх байх. Улс орон нэг л төсөвтэй

байдаг. Гэтэл манайд парламент нь төсвөө хянадаг хуулийн хэм хэмжээ алдагдсан. Үүнээс болж улсын хэмжээнд 4-5 төсөвтэй явдаг болсон. Ийм байдлаас болж төсвийн алдагдал дөрвөн их наяд төгрөг болж, түүхэнд байгаагүй хэмжээгээр тасарлаа. Иймд төсвийн алдагдлыг нөхөхийн тулд зарлага хумих зүйлсийг оруулж ирсэн. Өөрөөр хэлбэл, шүүгч, төрийн өндөр, төрийн захиргааны удирдах албан тушаалтны цалинг бууруулах тухай бүлэг дээр ярьж байгаад цалин хасахгүй байх улс төрийн шийдвэр гаргасан. Ингээд цалин хасах, татвар нэмэх асуудал МАН-ын бүлгийн улс төрийн шийдвэрээр буцаагдаж байна” хэмээсэн юм.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Э.МӨНХ

Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүхийн ахладаг Улсын Онцгой комисс шинэ бүрэлдэхүүнтэйгээр анхны хуралдаанаа хийлээ. Анхны хуралдаанаар хүнс, хөдөө аж ахуй, зам, тээвэр, эрчим хүч, эрүүл мэндийн салбар болон нийслэлийн өвөлжилтийн бэлтгэл ажлын явц, дөрөвдүгээр улирлын цаг агаарын төлөв байдлын талаар мэдээлэл сонсч шийдвэр гаргасан байна. Тодруулбал, өнөөдрийн байдлаар малчид 1.2 сая тн өвс, 100.0 мянган тн гар болон отроор шүүст, эрдэст тэжээл бэлтгэхээс 284 мянган тн хадлан /24 хувь/ бэлтгэжээ. Аймаг, сумын аюулгүйн нөөцөд 32 мянган тн өвс, 13 мянган тн тэжээл бэлтгэхээс 3722 тн өвс, 504 тн тэжээлийг бэлтгээд байна. Энэ жил нийт нутгийн 80 орчим хувьд мал өвөлжилт, хаваржилт хэвийн байх бол 14 аймгийн 47 сумын 4.6 сая мал отроор өвөлжиж, хаваржих төлөвтэй байна. Тиймээс салбарын яам малчдын дулаан хувцас, хүн эмнэлгийн болон малын эм, бэлдмэл, хөдөлмөр хамгааллын

багаж, хэрэгслийн багц, зөөврийн хашаа, саравчийг захиалгаар нийлүүлэх, мах болон ахуйн хэрэглээний барааны бартерын худалдаа зохион байгуулахаар төлөвлөжээ. Харин эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл ажил 2016 оны наймдугаар сарын 31-ний өдрийн байдлаар 70 хувьтай, Эрүүл мэндийн яамны харьяа 15 байгууллагад хийж байгаа их засварын ажлын явц мөн 70 хувьтай байна. Зам, тээврийн салбарынхан өвөлжилтийн бэлтгэлээ нэгдсэн төлөвлөгөөний дагуу хангаж байгаа бөгөөд цаг агаарын хүндрэлтэй үзэгдэл, түүнээс шалтгаалан замын хөдөлгөөн хэвийн үргэлжлэх боломжгүй нөхцөлд зам тээврийн осол, гэмтлээс иргэдийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, авран хамгаалах, учирсан хор аюулыг арилгах, сэргээн босгох үйл ажиллагааг зохион байгуулж ажиллах ажлын хэсэг” байгуулжээ. Хуралдааны үеэр холбогдох сайд, удирдах албан тушаалтнуудын мэдээллийг

сонссоны дараа Монгол Улсын Шадар сайд, Улсын Онцгой комиссын дарга У.Хүрэлсүх өвөлжилтийн бэлтгэл хангах талаархи Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлж, биелэлтэд хяналт тавьж, шуурхай удирдлагаар хангахыг аймаг, нийслэлийн Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт үүрэг болгов. Түүнчлэн гамшгийн улмаас учирсан хохирлыг эхний ээлжинд аймаг, нийслэлийн Онцгой комиссын эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэх, Засаг даргын нөөц хөрөнгө дууссан тохиолдолд хөрөнгийн зориулалт, зарцуулалтын тайлангаа ирүүлсний дараа Засгийн газрын нөөц сангаас хөрөнгө гаргах хүсэлтээ санхүүгийн баримтуудын хамт ирүүлж байхыг үүрэг болголоо. Эрчим хүч, дулаан, цахилгааны найдвартай тасралтгүй байдлыг хангах, нүүрсийг хугацаанд нь татаж авах, төлөвлөгөөт засвараа чанартай гүйцэтгэх, зам, давааг байнгын нээлттэй байлгахад анхаарч ажиллахыг ч анхаарууллаа. Мөн малчин өрх бүр малын хашаа, саравч, уст цэгээ засварлах, тохижуулах, түлээ түлшээ бэлтгэх, цаг агаар

ШИЙДВЭР ГАРГАХ ТӨВШИН ДЭХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ОРЛОЦООГ ОНЦЛОВ

Монгол Германы XIV чуулган өчигдөр Улаанбаатар хотноо эхэлсэн билээ. Энэхүү чуулганыг жил тутам Берлин Улаанбаатар хотод ээлжлэн зохион байгуулдаг бөгөөд энэ жилийн чуулганыг “Улс төрийн шийдвэр гаргах төвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоогоор дамжуулан ардчиллыг бэхжүүлэх нь” сэдвийн хүрээнд зохион байгуулж байна. Энэ жил болсон сонгуулийн дүн гарахад УИХ дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл нэмэгдсэн. Тэгвэл Монгол Улсын анхны Ерөнхийлөгч, Монгол Германы чуулганы тэргүүн П.Очирбат “УИХ дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл нэмэгдсэн нь сайн хэрэг боловч цаашид анхаарах зүйл багагүй бий” хэмээн онцолсон. Мөн “Эмэгтэйчүүдийг улс төрд идэвхтэй оролцуулах, тэр дундаа шийдвэр гаргах төвшин дэх эмэгтэйчүүдийн оролцооны асуудал бол дэлхийн нийтийн асуудал л даа. Манай Монголд бол онцгой чухал зүйл болоод байгаа юм. Энэ асуудал Германд яаж шийдэгддэг вэ гэдэг туршлагыг яриулах, өөрийн туршлагаа улс төрийн хүрээний эмэгтэйчүүдийн санаа бодлыг сонсох үүднээс энэ удаагийн чуулганыг зохион байгуулж байна. Эмэгтэйчүүд улс төрд орохын ач холбогдол хувь хүнд, нийгэмд ямар өгөөжтэй, хэрэгцээ шаардлагатай байна вэ, улс төрийн намууд эмэгтэйчүүдийг улс төрд оруулахад хэрхэн хандаж байна гэдгийг тодруулахыг хүсч байгаа юм. Улс төрийн намууд бол эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог төдийлөн дэмждэггүй. Албадан тогтоосон квотод л баригдаж байгаа болохоос улстөрч эмэгтэйчүүдийг эдийн засгийн боломжоор дэмждэггүй билээ. Олон сая төгрөгийн хандив гаргах боломж эмэгтэйчүүдэд тэр бүр байхгүй. Тиймээс эмэгтэйчүүдийг дэмжжэ гэвэл дэмжсэн шиг дэмжих хэрэгтэй байна. Нөгөөтэйгүүр эмэгтэйчүүд улс төрд ороход ар гэрийн бэрхшэлт тулгарх нь ч бий. Энэ бүхнийг голчлон анхаарч ярилцаж байна” хэмээсэн юм.

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг:
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот

Харилцах утас, факс:
976-70113551

“Монголын мэдээ” сонины редакцид эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэл үйлдвэрт хэвлэв.

ҮЗЭЛ БОДОЛ

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Энэ нь иргэдэд хүртээлгүй, баячуудад өгөх ёстой гэсэн үг бус уу. Газрын баялаг болсон алтыг тэрбумтнууд хэмжээ хязгааргүй ухан авч, эцэст нь байгаль орчныг яаж бохирдуулсныг, тэдэнд хууль дүрэм хэрхэн үйлчилдгийг Орхон голын жишээгээр бэлхэнээ хар. Гэтэл ядарсан ард түмэн самар түүжээр байгаль сүйтгэлээ гэнэ. Хориглож байгаа шалтаг нь инээдтэй. Модон мунаар хуш модыг цохихоор үхээд дуусна. Монголын хушин ойн нөөцийг барчихна гэнэ. Д.Хаянхярваа гишүүний хэлснээр ёстой битгий хуц. Самар түүж байгаа хүмүүс хог тариад, тэр нь байгалийг сүйрүүлээд байгаа гэсэн. Монголын төр өнөөдөр самар түүж, амьдралаа залгуулж байгаа ядарсан иргэдээрээ тоглож байхаар жинхэнээсээ байгаль орчин сүйдэлж байгаа баячуудтай хариуцлагын талаар эхлээд ярь. Өнөөдөр Орхон гол шавар шавхайгаар урсч байна. Архангай, Өвөрхангай, цаашлаад Булган, Орхон аймгийн олон иргэд, мал амьтан цэвэр усаар ундаалах

шившиг болгож байгаагаа мэдэж байна уу. Нэг япон хүн Монгол гуравхан сая хүнтэй, тэд нь ядуу юм уу. Тэгвэл би нэг арал дээр тэр гурван сая хүнийг нь авчирч тэжээ. Харин тэр том газар нутгийг нь өгчих гэсэн байна хэмээн бичсэнийг нүүр номоор нэг тараасан байна лээ.


Аливаа зүйлийг утга учиргүй хориглох нь дандаа муу үр дагавар дагуулдаг. Энэ жил самар түүлгэхгүйгэмуйхарлан хорьсноос болж хэдэн цагдаа, байцаагчид, ой хамгаалагч нар л башийлаа. Өвөрхангайн хэдэн суманд төрийн зарим албаныхан иргэдийг самар түүжээр ууланд гарахад нь

АЛТЧИН ТЭРБУМТНУУД БА САМАРЧИН АРД ТҮМЭН

...Хураасан самраа тэд улсын орлого болгоно гэж байх уу. Өөрсдөө л эд бад хийгээд, зүгээр байж байгаад мөнгөтэй болчихдог хэмээн нутгийнхан ярьдаг нь ортой биз. Харин ядарсан иргэд мөнгө төгрөг, цаг хугацаа, хөдөлмөрөөрөө “шатаад” л дуусна...

хориглоогүй. Зүгээр нүдэн балай оруулчихсан гэсэн. Хэд хоногийн дараа түүсэн самрыг нь очиж хураагаад, хөөгөөд явуулчих жишээтэй. Хураасан самраа тэд улсын орлого болгоно гэж байх уу. Өөрсдөө л эд бад хийгээд, зүгээр байж байгаад мөнгөтэй болчихдог хэмээн нутгийнхан ярьдаг нь ортой биз. Харин ядарсан иргэд мөнгө төгрөг, цаг хугацаа, хөдөлмөрөөрөө “шатаад” л дуусна. Уг нь манайхнаас өөр, ухааныжижигхэнхэлтэрхийтэй хүмүүс бол ард түмний самар түүхийг хориглож мэдрэлтэж байхын оронд харин ч татвар мөнгөө хураагаад, асуудлаа шийдээд явбал дээр биш үү. Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын удирдлагууд яаж байна. Самар түүж байгаа иргэдээсээ багхан татвар аваад, цугласан мөнгөөр нь хүүхдийн цэцэрлэг барьчихлаа. Яагаад энэ аргыг хангайн бүсийн, самар жимс ургадаг сумын удирдлагууд ашиглаж болохгүй гэж. Иргэд нь хэдэн төгрөгтэй болоод, амьдрал ахуйдаа нэмэрлэхинэ. Сумд нь ч гэсэн жаахан татвар аваад, түүгээрээ зарим асуудлаа шийдчихнэ. Бид ингэж ажиллаж, байгалийн баялгаа нийтээрээ хувааж идэх цаг болсон. Томчууд, баячууд нь Монголын өнгөтэй өөдтэй гэсэн бүхий л ашигт малтмал, байгалийн баялаг, алт эрдэнийг ухааж баяжиж байхад ядарсан иргэд нь ядаж самар ч болов түүж, бор ходоодоо борлуулах эрхтэй баймаар байх юм.

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



УИХ-ын дарга асан
Ц.Уушарьяа

...2006 **11** **07**
àí ùí îðèñàíí
òààààðùà
òàòèàèé, àyà
10% ò'èà'á
àíèàíí.
Àóí ààè àí àèé
äyì àèò àí àèíà
10 àèè yàñí ùà
ÌÁÍ áóòààèèà..

МОНГОЛЫН МЭДЭЭ
Манай сонины IV улирлын захиалга үргэлжилж байна
Улиралд **64** дугаар
захиалгын үнэ 18000
Монгол шуудан: 70078977
УБ шуудан: 70127027
Скай пост: 70121294
Түгээмэл шуудан: 70115025

МЭДЭЭЛЭЛ

Б.Баабар: БОЛОЛЦООГ АШИГЛАЖ ЧАДАХ ЭСЭХ НЬ МОНГОЛЧУУДААС ӨӨРСДӨӨС НЬ ХАМААРНА



Э.МӨНХ
Монгол Улсад хөрөнгө оруулагчдын “Инвест Монголиа” чуулга уулзалт болж байгаа билээ. Уг уулзалтад Монгол улсад үйл ажиллагаа явуулахдаа аль салбарыг сонгох вэ, оруулсан хөрөнгөө хэрхэн хамгаалах вэ, энэ Засгийн газар ирэх дөрвөн жилд тогтвортой байх уу, ямар бодлого хэрэгжүүлэх бол гэсэн асуултад хариулт хайсан гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид болон эдийн засаг, бизнесийн салбарынхан энд чуулж байна. Тэгвэл өчигдрийн уулзалтад нь нийтлэлч Баабар “Шинэ Засгийн газар хямралыг гэтлэхийн тулд юу хийх ёстой вэ” сэдвээр

байна. Цэрэг, цагдаа, хамгаалалт, харуул манаа зэрэг ажлын байранд 70 орчим мянган өндөр настай эрэгтэйчүүд хамрагдаж байна. Ийм л эрэлтэй ажлын байр бий болгох хэрэгтэй. Тухайлбал, аялал жуулчлал байна. Монгол Улсад жилдээ 50 мянга орчим гадаадын жуулчдын ирдэг” хэмээн илтгэлдээ дурьдсан. Түүнчлэн Гацууртын алтны ордыг нэн даруй эхлүүлэх хэрэгтэйг онцлоод хэрэв эхлүүлж чадахгүй бол Канадын компани Монгол Улсыг олон улсын шүүхэд өгч, бид Хан Ресурс компанид 100 тэрбум төгрөг алдсан шиг үйл явдал дахин давтагдана хэмээсэн. Мөн Монгол Улсад мөрдөгдөж буй 500 орчим хоорондоо зөрчилдөж байгааг залруулах хэрэгтэйг сануулсан. Эцэст нь тэрбээр “Өнөөгийн хямрал монголчуудаас өөрсдөөс нь болсон. Үүнийг монголчууд өөрсдөө л засч чадна. Бурхан хэрвээ байдаг юм бол монголчуудад бололцоо боловсрол олгохоос бүх насаар нь зүгээр тэжээмээргүй юм. Боллоцог ашиглаж чадах эсэх нь монголчуудаас өөрсдөөс нь хамаарна. Алдах бол хүний ёс, алдаагаа давтах бол мунхагийн илрэл” гэж, илтгэлээ өндөрлөсөн юм.

Дугаарын **60** мөр
Урамшуулал,
хариуцлагыг давхар
хэрэгжүүлбэ

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт
Харин хөгжиж байгаа болон хөгжингүй орнууд бол хамгийн шилдэг гэсэн цөөн хэдэн спортод маш сайн анхаарч, тэр төрлөөрөө л Олимпын наадмаас медаль авдаг. Манайхан зөвхөн топ дөрвөн спортод л анхаарлаа, бусдыг нь хаялаа гээд байдаг. Зөвхөн манай гэлтгүй дэлхийн бусад орнууд ч дэлхий, олимпоос медаль авах боломжтой төрлөө л илүүтэй анхаарч байна шүү дээ. Түүнээс биш Монгол шиг буурай оронд олон спортын төрөлд анхаарлаа хандуулж угаасаа чадахгүй, боломж ч байхгүй. Тэгэхээр одоо хөгжингүй орнуудын хэрэглэж байгаа урамшуулахын хажуугаар хариуцлага тооцдог системийг хэрэглэх цаг болсон. Тухайлбал, Английн Засгийн газар Олимпын наадмаас медаль авсан спортын төрлийн холбоог дөрвөн жил 100 хувь санхүүгээр хангадаг гэж байгаа. Харин медаль авч чадаагүй бол өөрсдөө хөрөнгө мөнгөө зохицуулах нь хэрэгтэй болдог гэж байгаа. Энэ систем л манайд хэрэгтэй байна. Одоо бол манай Засгийн газар Олимпын наадмаас медаль авсан ч бай, аваагүй ч бай хамаагүй, хүсэлт гаргасан бүхий л спортын төрөлд цөөн хэдэн төгрөгөө тарамдаад л дуусч байгаа. Риод гэхэд манай улс медаль авсан жүдо, боксоос гадна чөлөөт бөх, буудлага, хүндийн өргөлт, байт харваа, тасквондо, хөнгөн атлетик, усанд сэлэлт гээд цөөнгүй төрлөөр оролцдоо. Жүдогийн холбоо арай илүү ажиллаж байгаа тулдаа нэг мөнгөн медаль авчирлаа. Боксын холбооны үйл ажиллагаа нэлээд тогтворжиж, тамирчдын ур чадвар дээшлсэн болохоор медалиас мултасангүй. Чөлөөтийн хувьд медаль хүртэх хангалттай боломжтой байсан ч холбооныхон нь тамирчид, дасгалжуулагч нартайгаа эв эе ололцоогүйгээсээ болоод медальгүй хоцорсон. Буудлага дээр бол манай тамирчдын ур чадвар, бэлтгэл сургуулиг бусад орныхоос дутмаг л байна. Бусад төрлийг одоохондоо яриад хэрэггүй. Тэгвэл ирэх дөрвөн жилд медаль хүртсэн жүдо, боксоо тулгал нь дэмжээд, хэрэгтэй хэрэггүй төрөлд зарцуулдаг мөнгөө тэдэнд өгвөл ясан юм. Бусад нь өөрсдөө учраа олоод үйл ажиллагаагаа явуулна биз. Тэгээд Токюогийн Олимпын наадмаас 4-5 медаль, цаашлаад Олимпын аварга төрвөл болоо биз дээ. Спортын олон төрөлд оролцож, сүүл мушгиж байгаа тамирчдаа хараад суух нь дээр үү. Цөөн хэдэн төрөлд найдвартай медаль хүртдэг, аварга төрдөг байх нь дээр үү гэдгийг бодох л хэрэгтэй. Хамгийн гол нь энд цэвэр өрсөлдөөн өрнөх юм. Бусад спортын төрлүүд Олимпын наадамд амжилт гаргаж, төрийн ивээлд багтахын төлөө зүтгэдэг, өрсөлддөг цэвэр өрсөлдөөний зарчим энд бас үйлчилнэ шүү дээ. Нэг л амжилт гаргаад, төрийн ивээлд багтчихвал түүнийгээ алдахгүйн төлөө бас зүтгэнэ. Энэ чинь шударга зарчим. Жүдо, боксынхон дараагийн Олимпын наадмаас медаль авч чадахгүй бол төрийн ивээлээс мултарт болно. Ийм л урамшууллын болон хариуцлагын системийг хэрэглэх цаг болжээ. Түүнээс биш тамирчдаа хий муулаад асуудал шийдэгдэхгүй л болов уу.

ОНЦЛОХ ХУУДАС

Speak out

Ипотекийн зээл
зогсохгүй...

Н.БАТЗАЯА

Орон сууцны найман хувийн хүүтэй ипотекийн зээлийг олгох эсэх асуудал иргэдийн дунд эргэлзээтэй асуудал болон хувирсан. Нэг хэсэг нь зээлийг үргэлжлүүлнэ хэмээж байгаа ч нөгөө хэсэг нь зогсоох нь зөв хэмээн үзэж буй. Тиймээс энэ удаагийн "Онцлох хуудас" булангаараа энэ сэдвийг хөндөж, албаны хүмүүсийн байр суурийг сонссоноо хүргэе.

Г.Мөнхбаяр: Ипотекийн зээлийг үргэлжлүүлэн олгоно

/Барилга, хот байгуулалтын сайд/

Х.Маргад-Эрдэнэ: 52 мянган зээлдэгчийн 2.4 их наяд төгрөгийн зээлийг үнэт цаасжуулсан

/Монголын ипотекийн корпораци компанийн Ипотекийн хөрөнгийн үнэлгээний хэлтсийн дарга/

2013 оны зургадугаар сарын 14-өөс одоог хүртэл орон сууцны ипотекийн зээлд хамрагдсан 28 мянган зээлдэгч байна. Эдгээр хүмүүст нийт 2.9 их наяд төгрөгийн зээлийг арилжааны банкууд олгосон байна. Харин 52 мянган зээлдэгчийн 2.4 их наяд төгрөгийн зээлийг арилжааны банкуудаас худалдаж аваад, үнэт цаасжуулаад, хөрөнгө оруулагчдад зарсан. Энэ хугацаанд зарим зээлдэгчид зээлээ

А.Ганзориг: Монголбанкны санхүүжилт удаашралтай байна

/Хас банкны хувийн банкир/

Монголбанкнаас санхүүжүүлж байгаа ипотекийн найман хувийн зээлийг Хас банк олгож байгаа. Сүүлийн үед орон сууцны зээлд хамрагдах хүсэлтэй иргэдийн тоо нэмэгдсэн. Үүнийг дагаад энэ төрлийн зээлийн үйлчилгээ ч идэвхижиж байна. Өөрөөр хэлбэл, үйлчлүүлэгчдийн хүсэл сонирхлоос хамаараад

Ц.Ганзориг: Иргэдээс ипотекийн зээлийн хүсэлтийг хүлээн авч байна

/Төрийн банкны Зээлийн бодлого зохицуулалтын газрын захирал/

Төрийн банк Монголбанкны баталсан орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийн ерөнхий журмын дагуу орон сууцны ипотекийн зээлийг иргэдэд олгож байгаа. Манай банк ипотекийн орон сууцны зээлийг олгож эхэлснээс хойш найман хувийн зээлийг 5831 үйлчлүүлэгчид олгосон. Эдгээр

С.Энхболд: Ипотекийн зээлийн олголтыг зогсоосон

/Худалдаа хөгжлийн банкны Иргэдийн банкны менежер/

-Манай Худалдаа хөгжлийн банкны хувьд орон

төлөөд, хаасан байх. Мөн нөгөө хэсэг нь зээл аваад орон сууцаа барьцаанаас чөлөөлсөн ч тохиолдол бий. Ингээд одоогийн байдлаар 49 мянган зээлдэгчийн 2.2 их наяд төгрөгийн зээл үнэт цаасжуулагдаагүй үлдсэн. Санхүүгийн зохицуулах хорооноос манайд үнэт цаас гаргах зөвшөөрлийг олгодог. Одоогоор үнэт цаасны зөвшөөрөл нь хүлээгдэж буй зээлдэгчид өгсөн нь зөв болов уу. Иргэд МИК-ээс найман хувийн зээл олгодог. МИК санхүүжилтийг нь өгдөг гэж ойлгодог. Энэ бол буруу. Манайх зөвхөн арилжааны банкуудаас зээл авч, авсан зээлээ үнэт цаасжуулдаг. Үнэт цаасжуулахын ач холбогдолдыг иргэд сайн мэдэхгүй байж болох. Тэгэхээр үнэт цаасжуулсны ач холбогдол нь юу вэ гэвэл нэг удаа банкнаас хоёр зээлдэгчид тус бүр 100 сая төгрөгийн зээл олголоо гэж бодъё. Нийт 200 сая төгрөгийн зээл болно. Энэ

ипотекийн зээлийн үйлчилгээ нэмэгдэж байна гэсэн үг. Одоогийн байдлаар манай банкаар орон сууцны найм болон таван хувийн хүүтэй зээл гарч байгаа. Манай банк үйлчлүүлэгчдээсээ ипотекийн зээлийн хүсэлтийг хүлээж авч байна. Санал хүсэлтийг нь хүлээж аваад, шийдвэр гарсан зээлүүд ч бий. ямар нэгэн зээл олгосон тохиолдолд эргэн төлөлт гэж асуудал гарч ирдэг. Манай банкнаас ипотекийн найм болон таван хувийн зээл авсан үйлчлүүлэгчдийн эргэн төлөлт сайн байгаа. Эргэн төлөлтийн хувь харьцангуй гайгүй байна. Ипотекийн хоёр зээлийн эргэн төлөлт хийгдэж байгаа. Ер нь зээл чинь буцаан олголтороо санхүүжиж явдаг. Тухайлбал, та манай банкнаас орон сууцны найман хувийн зээл авлаа гэж

иргэдийн зээлийн хэмжээ нь зургаан тэрбум төгрөг болж байгаа юм. Өөрөөр хэлбэл, 5831 зээлдэгчид зургаан тэрбум төгрөгийн зээл олгосон гэсэн үг. Харин таван хувийн зээлийг 824 хүнд олгожээ. Ингэхдээ нийт 34.7 тэрбум төгрөгийн зээлийг олгосон байгаа юм. Манай компани өнгөрсөн хугацаанд ийм зээлийг олгосон. Орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилт Монголбанкнаас ирдэг. Тус банкаас ирсэн эх үүсвэрээр бид байгаа нөхцөлдөө тохируулан иргэдэд найм болон таван хувийн зээлийг олгодог. Үүний дараа иргэдээс авсан зээлээ Монголын ипотекийн корпорацид худалддаг. Ийм л зарчим явагдаж байгаа. Өнгөрсөн зургадугаар сард сонгууль болж өндөрлөлөө. Сонгуулийн үр дүнгийн дараа буюу долдугаар сараас эхлэн бидэнд

орон нутагт таван хувийн хүүтэйгээр уг зээлийг олгох юм. Мөн энэ ажлыг хариуцаж буй ажлын хэсэг сард төлөх төлбөрийн хэмжээг багасгах тал дээр ажиллаж байгаа. Зөвхөн энэ зээлийг олгохоос гадна иргэдээс хүсч байгаа хэд хэдэн асуудал байна. Тухайлбал, м.кв-ын асуудал. Одоо найман хувийн хүүтэй зээлээр дээд тал нь 80 м.кв хүртэлх байрыг л өгч байгаа. Тэгэхээр олон ам бүлтэй айлд м.кв-ынх нь хэмжээ дэндүү бага байна гэх хүсэлтийг иргэд өгч

хэмжээний зээлийг иргэдэд олгохоор тухайн банк өөрөө эх үүсвэргүй болчихож байгаа юм. Энэ үед үнэт цаасны компани иргэдээс авсан зээлийг 200 саяар нь тухайн банкнаас худалдаж авч, үнэт цаасжуулдаг. Ингэснээр арилжааны банкууд дараагийн хүнд зээл олгох эх үүсвэртэй болж байгаа юм. Далгэрэнгүй хэлбэл, банк 200 сая төгрөгийн хоёр хүнийхээ зээлийг үнэт цаасны компанид 200 сая төгрөгөөр зарчихлаа. Магадгүй 200 сая төгрөгийн зээлдэгч нь зээлээ төлсөөр байгаад 199 сая болсон ч байж болно. Энэ үед арилжааны банк манайд 199 сая төгрөгөөр зарж болох юм. Ингэснээр банк өөрөө эх үүсвэртэй болоод зээлээ зарсан эх үүсвэрээрээ дараагийн хоёр, гурван зээлдэгчид тодорхой хэмжээний зээл олгох нөхцөл бүрдэнэ. Энэ процессыг л бий болгох, санхүүгийн механизмыг хөдөлгөөнд байнга оруулах юм. Ер нь байнга хөдөлгөөнд байх ёстой. Хүмүүс орон сууцтай болохын тулд 20-30 жилийн хугацаатай зээл авч байгаа ч ам бүлийн тоо нэмэгдэнэ, хасагдана гээд янз бүр байж болно шүү дээ. Энэ хэрээр орон

бодъё. Тэгвэл манайхтай байгуулсан гэрээнийхээ дагуу сар бүр тодорхой хэмжээний мөнгө төлөх ёстой болдог. Хэрвээ та тэр мөнгөө сар бүрдээ төлөхгүй бол банк дараагийн хүнд зээл олгох боломжгүй болно. Нэг үгээр хэлбэл, эхний үйлчлүүлэгчийн эргэн төлөлтөөр дараагийн үйлчлүүлэгчид зээл олгодог гэсэн үг. Гэхдээ энэ банкны санхүүжилтын нэг хэсэг нь. Өөр санхүүжилтын эх үүсвэрүүд бий. Гэсэн ч эргэн төлөлт банкны санхүүжилтэд чухал нөлөө үзүүлдэг. Мөн нэг зүйл бий. Ипотекийн зээл чинь Монголбанк, Монголын ипотекийн корпорацинаас санхүүждэг. Хэдийгээр манай банкнаас шийдвэр гаргаад олголт хийж байгаа ч эх үүсвэр нь хүлээгдэж байна. Монголбанкнаас санхүүжилт

Монголбанкнаас санхүүжилт олгоогүй. Манай банкнаас тодорхой хугацаанд холбогдох газарт санхүүжилтээ нэхэмжилж, хүсэлт хүргүүлсэн. Гэсэн ч одоогийн байдлаар санхүүжилт орж ирээгүй л байна. Үүнтэй уялдуулаад бид өөрсдийн эх үүсвэрийн хүрээнд тодорхой хэмжээнд бага зэргийн зээлийг олголоо. Харин одоо өөрийн эх үүсвэрээр ипотекийн зээлийг иргэдэд олгох боломжгүй болсон. Тиймээс бид түр хугацаанд Монголбанкнаас санхүүжилт орж ирэх хүртэл ипотекийн зээлийг олгохгүй. Зөвхөн орон сууцны найм болон таван хувийн зээлд хамрагдах сонирхолтой иргэдийн хүсэлтийг хүлээж авч байгаа. Мөн авсан хүсэлтүүдээ цаанаас тавьсан тодорхой шалгуурын дагуу хянаж үзээд шийдвэр гаргаж байна. Яг цэвэр олголт хийгдээд явж байгаа

сууцны найм болон ипотекийн зээлийн хүсэлтийг хүлээн авч байгаа. Уг зээлд хамрагдах сонирхолтой иргэд манай банкинд хандаж байна. Энэхүү зээлийн санхүүжилт Монголбанкнаас орж ирдэг. Одоогийн

байгаа. Мөн энэ хэмжээ зорилготой бүлэгтэй хүрчихлээ шүү дээ. Цаашид талбайг нь томсгож, 80-100 м.кв гэх хувилбар руу шилжүүлэх нь зүйтэй гэж үзсэн. Энэ тал дээр судалгааны ажил ч хийгдэж байна. Товчхон хэлэхэд ипотекийн зээлийг үргэлжлүүлэн олгоно.

сууцны зээлийн хэрэгцээ нэмэгдэнэ. Өөрөөр хэлбэл, нэг өрөө байртай бол хоёр өрөө байртай болох гэж хүснэ. Ам бүлийн тоо нэмэгдэхээр иргэд ч байрныхаа талбайг томруулахыг л болно. Үүнээс шалтгаалаад орон сууцны зээлийн хэрэгцээ гарч байдаг. Энэхүү зээлийн хэрэгцээ огт байхгүй болно гэж байхгүй. Тодорхой хэмжээнд өсөн нэмэгдэж, тогтоод байж байдаг. Тэр хэмжээнийг л хадгалахын тулд банкинд эх үүсвэр нь тодорхой хэмжээгээр байх ёстой. Байнгын байж байдаг. Харин бид зах зээл дээр байгаа бусад сул чөлөөтэй хөрөнгүүдийг энэ зах зээл рүү оруулж ирдэг. Ингэснээр хүмүүсийг зээлд хамруулдаг. Энэ процессыг үнэт цаасжуулах үйл ажиллагаагаар санхүүжүүлдэг. Товчхон хэлэхэд МИК арилжааны банкны зээлийг худалдан авч, үнэт цаасжуулдаг. Ингэснээр банк дараагийн зээлийг олгох эх үүсвэртэй л болж байгаа юм.

хүлээгдээд байна л даа. Тухайлбал, банк шийдвэр гаргаад гэрээний дагуу Монголбанкнаас эх үүсвэр хүснэ. Монголбанкнаас санхүүжилт орж ирсний дараа олголт нь хийгддэг. Тэгэхээр тус банкнаас санхүүжилт орж ирэхгүй байгаа учраас зээлийн олголт хийгдэхгүй тохиолдол бий. Үүнээс шалтгаалсан удаашрал бол бий. Дахин хэлэхэд манай банк ипотекийн найм болон таван хувийн зээлийг олгож байгаа. Энэ зээлийг авахыг хүссэн иргэд ч цөөнгүй байна. Гэхдээ Монголбанкнаас орж ирэх санхүүжилтээс шалтгаалан олголт удаахрах хандлага харагдаж байна.

зүйл алга. Иргэдийн хүсэлтийг хүлээж аваад, судалж үзсний дараа шийдвэр гаргах хэмжээнд л явагдаж байна. Бид эх үүсвэр орж ирэх л юм бол зээлийн олголтыг хийх болно. Тиймээс харилцагчдад хандаж хэлэхэд эх үүсвэр орж ирэх хүртэл олголт хийгдэхгүй нь гэдгийг хаа хаанаа ойлгохгүй байгаа. Энэ бол бүхэл бүтэн систем ойлголт явагдаж байгаа юм. Гэхдээ орон сууцны зээлд хамрагдах хүсэлтээ манай банкинд өгч болно. Өгсний дараа шийдвэр гарсан ч олголт хийгдэх нь удаж магадгүй. Бид Монголбанкнаас санхүүжилт орж ирвэл олголтыг хурдан хугацаанд хийнэ.

байдлаар санхүүжилт орж ирсэн зүйл алга. Тиймээс бид зээлийн олголтыг зогсоосон. Зөвхөн иргэдийн хүсэлтийг л хүлээж авч байна.

ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

60-УУЛАА ШАХЦАЛДАЖ

–Ирэх жилүүдэд сургуулийн хүрэлцээ улам ч дордож магадгүй–

Н.БАТЗАЯА
Б.ДАВААХҮҮ

Хичээлийн шинэ жилийн нээлт өнгөрсөн долоо хоногийн пүрэв гарагт орон даяар зохион байгуулагдсан билээ. Дүрэмт хувцсаа дэгжин гэгч нь

өмсч, салаа гэгээ өнгийн туузаар ороосон сэргэлэн охид, үеийн нөхдөө зуны сарын турш санаж үгүйлсэн сахилгагүй хөвгүүд эрдмийн өргөөгөө зорьж, хичээл номдоо шамдаж эхэлсэн. Гэвч тэдний сурч боловсрох орчин, эрх нь зөрчигдсэн хэвээр. Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй төрийн өмчийн 130 гаруй

сургуулийн ихэнх нь гурван ээлжээр хичээллэж, 50 гаруй хүүхэд нэг танхимд “шавсан” дүр зураг нийслэлийн эргэн тойронд байсаар байна. Тиймээс манай сонин энэ удаа төрийн өмчийн ЕБС-ийн анги дүүргэлтийн асуудлыг хөндөж сурвалжиллаа.

Нийслэлийн 24
сургууль гурван
ээлжээр хичээллэнэ

2016-2017 оны хичээлийн жилд улсын хэмжээнд ерөнхий боловсролын 790 гаруй сургуульд 561600 сурагч суралцаж байна. Тэдний 69100 хүүхэд нь нэгдүгээр ангид элсэн суралцагчид ажээ. Тэгвэл зөвхөн нийслэлийг сонирхож үзвэл, 224 ерөнхий боловсролын сургууль үйл ажиллагаа явуулж байгаагаас төрийн өмчийн 135, төрийн бус өмчийн 89 сургууль бий. Эдгээр ерөнхий боловсролын сургуульд энэ хичээлийн жилд нийтдээ 230 гаруй мянган хүүхэд суралцах юм байна. Тэдний 31 мянган хүүхэд нь нэгдүгээр ангийн сурагчид аж. Хичээлийн шинэ жил эхлэхтэй зэрэгцэн сургуулийн хүрэлцээний асуудал сөхөгдөж эхэлдэг нь нууц биш. Тэгвэл 2016-2017 оны хичээлийн жилд нийтдээ 20 гаруй сургууль гурван ээлжээр хичээллэхээс өөр аргагүй гэдгийг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ж.Батсуурь саяхан хэвлэлд өгсөн ярилцлагадаа дурьдсан байв. Гэхдээ энэ тоо буурч байгааг сайд онцолсон байсан. Харин манай сурвалж хэсэг Нийслэлийн боловсролын газрын мэргэжилтнээс энэ талаар тодруулахад, “Энэ жилийн албан ёсны статистик мэдээлэл гараагүй учир бүлэг дүүргэлтийн талаар нарийн тоон мэдээлэл өгөх боломжгүй. Урьдчилсан байдлаар 236 мянган хүүхэд ЕБС-д хамрагдаж байна. Өнгөрсөн жилийн байдлаар Баянзүрх дүүргийн 110, 33, 84, Сүхбаатар дүүргийн 1, 31, Чингэлтэй дүүргийн 23, 5, Хан-Уул дүүргийн 18, 52, Буянт-Ухаа цогцолбор зэрэг сургуулиуд бусдаасаа хэт өндөр ачаалал авч, анги дүүргэлт нь 50-д хүрч гурван ээлжээр хичээллэсэн” гэлээ. Ерөнхийдөө нэг ангид ихдээ 40 хүүхэд суралцах нормтой ч, энэ стандарт эдүгээ мөрдөгдөхгүй байна. Нийслэлийн ихэнх сургуулиудын бага ангийн сурагчдын анги дүүргэлт аль хэдийнэ 50-д хүрчээ. Тиймээс зарим сургуулиудын хувьд дээрх стандартад дөхөж очихын тулд ээлжийн тоог



нэмэх шаардлагатай тулгардаг аж.

Нэг бүлэг 50
хүүхэдтэй

....Танай анги хэдэн сурагчтай вэ?

-48
-Хэддүгээр анги вэ. Бүлэг чинь?

-5г
-Тэгвэл танай ангийн хүүхдүүд нэг ширээнд гурвуулаа суудаг байх нь ээ?

-Тийм. Гэхдээ би бол хоёулаа суудаг. Зарим хүүхдүүд гурвуулаа суудаг юм.

-Ийм олуулаа нэг ангид байх хэцүү юу?

-Гоё.....
Ататуркийн нэрэмжит тавдугаар сургуулийн коридороор алхаж явахдаа таарсан Э.Энхжин охин асуусан асуултад минь ингэж хариулав. Нэг ангид олон хүүхэд суралцсанаар хэн нэгэн найз нь хичээлээсээ хоцорно, эсвэл өвлийн улиралд дэгдэлт нь ихэсдэг ханиад, томуу тусна гэж цэрвэхгүйгээр “Олуулаа

сурах гоё” гэж хариулах энэ охин нийслэлийн ЕБС-ийн хэдэн зуун мянган сурагчдын нэг жишээ. Тавдугаар сургууль гурван ээлжээр хичээллэдэг бөгөөд бага ангийнхны анги дүүргэлт аль хэдийнэ 50-д хүрчээ. Сургуулийн коридороор явж, хоёр давхарт гаран захирлын өрөөний үүдийг тогшоо. Тус сургуулийн захирал Н.Гэндэнсүрэн тун завгүй сууна. Түүний хэлж буйгаар сургууль эдүгээ гурван ээлжээр хичээллэж буй аж. Мөн энэ жил ахлах ангийн сурагчид зургаан хичээлийг сонгон суралцах болсноор хичээлийн хуваарь гаргахад багагүй асуудал үүсч байгааг нуутаагүй. Сурагчид өөрсдийн судлах хичээлээ сонгох болсноор зарим анги 50, зарим нь 20 орчим болж эрс тэс ялгаа гарах болсон гэнэ. Харин бага ангийн ихэнх бүлэг нь 50 орчим сурагчтай аж. Тэдний хувьд нэг ширээнд гурвуулаа суух энүүхэнд. Гэвч ахлах ангийн сурагчдын хувьд 50-улаа нэг танхимд чихнэ гэдэг амаргүй даваа. Түүнчлэн гурван ээлжээр хичээллэж байгаатай

холбоотойгоор тус сургууль дээр явагддаг дугуйлангууд хагас сайнд хичээллэж, багш нар нь долоо хоногийн зургаан өдөр ажиллах болжээ.

960 хүүхдийн
багтаамжтай сургуульд
2010 хүүхэд суралцаг

Манай сурвалжлах хэсгийн дараагийн зогсоол Чингэлтэй дүүргийн 50 дугаар сургууль байв. Тус дүүргийн VI хорооны барилгатай хаяа дэрлэн орших энэ сургууль 2016-2017 оны хичээлийн жилд нийт 54 бүлэгт 2010 хүүхэд сургах ажээ. Харин анги дүүргэлтийн тухайд дунджаар 37 гэнэ. Хамгийн олон хүүхэдтэй бүлэг нь нэг, хоёрдугаар ангийнхэн бөгөөд ихдээ 49 хүүхэд нэг танхимд суралцаж аж. Ахлах ангийн сурагчдын хувьд харьцангуй гайгүй гэдгийг тус сургуулийн сургалтын менежер О.Бөхчулуун хэлж байлаа. Тус сургууль эдүгээ хоёр ээлжээр хичээллэдэг байна. Гэвч сүүлийн жилүүдэд бага ангид элсэн суралцагчдын

тоо эрс нэмэгдэж буй бөгөөд цаашдаа гурван ээлжээр хичээллэхийг үгүйсгэхгүй гэнэ. Анх сургуулийн барилга 960 хүүхдийн багтаамжтайгаар ашиглалтад орж байсан ч, эдүгээ энэ тооноос 2.5 дахин хэтрүүлж, 2010 суралцагч хүлээн авч, сурган хүмүүжүүлж байна.

23 дугаар сургуулийн
нэг ангид ихдээ 60
хүүхэд сурч байна

Бидний очсон дараагийн сургууль бол гадаад хэлний гүнзгийрүүлсэн сургалттай 23 дугаар сургууль. Манай сурвалжлах хэсгийг очих үед тус сургуулийн нэгдүгээр ээлжийн хичээл тарж, хоёрдугаар ээлжийн хичээл эхлэх дөхсөн тул сурагчдаа анги ангиар нь оруулж байв. Сургууль руу ормогч л энд тэндгүй хүүхдийн инээд цангинаж, хааяа нэг багшийн “чимээгүй” гэх дуу хадан, бүтэн гурван сарын турш эзнээ хүлээн дүнхийн байсан сургуулийн танхим дүүрсэн байлаа. Сургуулийн коридороор

зөрж өнгөрөх хүүхдийн тооноос харахад л 23 дугаар сургууль ачаалал ихтэй нь илэрхий байв. Бид юун түүрүүнд сургуулийн эрхлэгчтэй уулзах гэж яарсангүй. Сургуулийн эргэн тойртой танилцан, сурагчидтай ярилцсан юм. Хичээл орсон шүү гэсэн шиг сурагчидхаасайгүй гүйцээж байлаа. Бидний нүдэнд хамгийн түүрүүнд том цүнхээ дааж ядан үүрэх, жижигхэн биетэй охин тусч, түүнтэй хэдэн хором ярилцлаа. Түүнийг Х.Энхдарь гэдэг. Тэрбээр дөрөвдүгээр ангид сурдаг бөгөөд анги нь 58 хүүхэдтэй гэнэ. Харин сургуулийн анги дүүргэлтийн талаар бидэнд ярихдаа “Нэг ангид олон хүүхэд сурах нь тийм ч муу зүйл биш гэж би боддог. Олон найзуудтай болно шүү дээ. Бас хичээл ч хөгжилтэй явагдана. Би олуулаа байхад дургүй. Надад таалагддаг. Харин зарим хүүхдүүд дургүй байх” гэв. Ингэж хэлсээр том цүнх нь хүнддсэн аятай дээш нь нэг өргөөд манай сургуулийн сургалтын менежер дөрвөн давхарт суудаг юм шүү гэсээр явж одов. Дараа нь бид наймдугаар ангид сурдаг охинтой таарав. Г.Мишээл охин эмч болох хүсэлтэй учраас орос хэлийг сонгон суралцаж буй тухайгаа бидэнтэй хуваалцсан. Харин түүний хувьд ангид олон хүүхэд байх нь тухайн сурагчийн сурлагын амжилтад нөлөөлдөг гэж боддог ажээ. Нэг ангид хэтэрхий олон хүүхэд байх нь багшийн хүүхэд бүртэй тулж харьцах боломжийг багасгадаг гэнэ. Тэрбээр энэ тухай “Манай анги 48 хүүхэдтэй. Гэхдээ бусад ангийг бодвол харьцангуй гайгүй л дээ. Бусад ангид 50-60 хүүхэд бий. Миний бодлоор нэг ангид олон хүүхэд байх нь тухайн багшийн хүүхэд бүртэй тулж харьцах боломжийг хаадаг юм шиг санагддаг. Яах вэ, тухайн хүүхдийн хичээл зүтгэлээс бас шалтгаалах байх. Багш заавал над дээр ирэх ёстой гээд суугаад байх болохгүй. Өөрөө очоод багшийнхаа араас хөөцөлдөж болно шүү дээ. Ер нь тэгэх ёстой байх. Тэгж байж л мэдлэг олж чадна” гэсэн юм. Мэдээж аливаа мэдлэгийг олж авахад тухайн хүүхдийн өөрийнх нь идэвх чармайлт чухал. Гэхдээ чармайлт байлаа гээд хичээлийн 40 минутад багшаас хэрэгтэйгээ



Цулэн сүүдэр



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Бидэнд тохиолдсон



ХҮНДХЭН ХӨГТЭИ ЯВДЛУУД



Золбоо Идэрцогт

Өглөө хүүгээ албанд нь хүргэж өгөх ажилд босоод л, зодоглож эхлэв ээ. Хүү ч уйлаад цэцэрлэгтээ явахгүй энэ тэр гээд л... Бөөн уйлаан. Хувцаслаж дуусаад машиндаа суулгаад явав. Хүү маань 3 настай, урд суудал дээр суугаад л уйлаад байна. Өнөр хорооллын гарцан дээр очтол шар гэрэл асаад улаан болчихов. Би ч гараад явчихлаа. Жаахан яарч явсныг ч хэлэх үү. Тэгтэл хүү уйлж байснаа болиод "Аав та улаан гэрлээр гарчихлаа. Сая улаан гэрэл ассан" гээд л үглэж гарав. Жолооны багш юм уу, хаашаа юм. Би ч хүүгээ хараад инээд хүрээд, цаашаа явав. Тэгтэл Мөнгөн гүүр эмнэлгийн хажууд цагдаа нар үлээлгээд зогсож байна. Тэгэхээр нь "Чи уйлаад байсан болохоор цагдаа нар зогсоож байна" гээд л хүүгээ уйлуулахгүй гэсэн чинь яг үлээх мөчид хажуу талаас "Аав сая улаан гэрлээр гарсан" гээд л хэлээд авдаг байгаа. Би ч инээгээд, цагдаа ч инээгээд л өнгөрсөн. Хүүхдүүд нээрээ хэзээд үнэнийг хэлнэ шүү.

ОДЫН АМЬДРАЛ

Рианнагийн СОДОН гоёл



Б.ДАВАА

Хөгжмийн ертөнцөд өөрийн гэсэн дуу хоолойгоороо бусдаасаа ялгарч чаддаг дуучин Рианна тун өвөрмөц имижтэй нэгэн. Түүний аливаа хөгжмийн наадам, баяр ёслолд сонгосон гоёл хийгээд жирийн үед өмссөн хувцас нь ч олны анхаарлын гадуур өнгөрдөггүй гэхэд болно. Тэгвэл дуучин бүсгүй өнгөрөгч амралтын өдрүүдэд нэгэн содон хувцас өмссөн байсан гэнэ. Бүсгүй аварга том улаан зүрхэн үеелг хүрмийг богино жинсэн богино өмдтэй хосуулан өмсч, Нью-Йоркийн гудамжаар алхаж явсан сурагтай. Олны анхаарлыг татаж,

зарим эмэгтэйчүүдийн шуналыг хөдөлгөсөн бүсгүйн үеелг гоёл 15500 ам.долларын үнэтэй аж. Ерөнхийдөө зун дууссаны дараагаас эхлэн барууны одод үеелг эдлэлээр гангарах нь элбэг байдаг. Гэхдээ Рианнагийн сонгосон гоёлын хэлбэр, өнгө дүрс нь ч сонин содон байгаа биз. Бүсгүй энэ өдөр найзынхаа төрсөн өдөрт оролцож явжээ. Рианнагийн хувьд саяхнаас шар сайтуудын гаргасан цуурхал төдий мэдээлэлд цэг тавьж, репшер Дрэйктэй дотно харилцаатай гэдгээ тоглолтынхоо үеэр баглаад амжсан юм. Ямартай ч, хайр дурлалдаа умбаж яваа бүсгүйн найзынхаа жирийн нэг төрсөн өдрийн баярт зориулан сонгосон гоёл нь ийм байна.

ДУУЛГАХ СОНИН

Паралимпийн XV наадам өнөөдөр эхэлнэ

Бразилын Рио-Де-Жанейро хотноо паралимпийн XV наадам энэ сарын 07-ны өдөр буюу өнөөдөр эхлэх бөгөөд манай улсаас байт харваа, жудо, буудлага, хөнгөн атлетик, пауэрлифтинг гэсэн төрлөөр найман тамирчин өрсөлдөх юм. Энэхүү наадамд дэлхийн 173 орны баг тамирчин спортын 23 төрлөөр 528 медалийн төлөө өрсөлдөнө. Монгол Улсыг төлөөлөн оролцож буй тамирчинд энэ сарын 08-аас эхлэн Риогийн дэвжээнд гарна. Тодруулбал, энэ сарын 08-нд хөнгөн атлетикийн төрөлд Г.Цогтгэрэл гарах бол жудо бөхийн дэвжээнд А.Мөнхбат, Б.Ууганхүү нар зодоглоно. Мөн 09-нд буудлагын төрөлд З.Ганбаатар, 10-нд байт харвааны төрөлд Д.Баатаржав, Б.Оюун-Эрдэнэ, А.Анхбаяр нар өрсөлдөнө. Харин 13-нд пауэрлифтингийн төрөлд Э.Содномпилжээ гарах юм.

Ким Кардашьяны ээлжит "ИЖИЛСЭЛТ"

Зөвхөн Америкт гардаг реалити шоууг хөтөлдөг атлаа хувцаслалт, төгс бие галбираараа дэлхий даяар од болж чадсан бүсгүй бол Ким Кардашьян. Бүсгүй дуучин Канье Уэсттэй нижгэр хурим хийж, хоёр хүүхдийн ээж болсон ч, гоолиг биеэ хадгалан үлдэж чадсан нэгэн. Тиймдээ ч түүний хувцаслалт, загварын мэдрэмж үргэлж олны харцыг булаадаг. Тэгвэл реалити шоуны од бүсгүй саяхан Мадисон Скюэр Гарденд зохион байгуулагдсан нөхрийнхөө тоглолт дээр охинтойгоо яг ижилхэн хувцас өмсөж, олны нүдийг орой дээр нь гаргах дөхсөн гэнэ. Ким энэ үдэш гурван настай охин Норт Уэстээ дагуулан нөхрийнхөө тоглолтод ирсэн байна. Улмаар ээж охин хоёр яг ижил мөнгөлөг гялалзсан даашинзаар гоёсон нь хурсан олныг алмайруулсан сурагтай. Кимийн өөртөө сонгосон

даашинз нь Вэтлмэнтийн сүүлийн загвар бөгөөд 9734 ам.долларын үнэтэй аж. Түүнчлэн өөрийн даашинзыг яг дуурайлган урлуулсан охиных нь даашинз мөн төдий хэрийн үнэтэй гэнэ. Ээж охин хоёрын ялгаа гэвэл гутал нь байжээ. Ким өнгөгүй өндөр өсгийт сонгосон бол Норт охин хөлд эвтэйхэн кейт өмссөн байжээ. Реалити од бүсгүйн хувьд анх удаагаа охинтойгоо ижилсэж буй нь энэ биш. Одоогоос хоёр жилийн өмнө Парисын загварын долоо хоногт оролцсон Ким торон хослолоор охинтойгоо ижилсэж байв. Тухайн үед дөнгөж нэг нас хүрч байсан охиноо өөртэйгөө адил торон даашинзаар гоёсон нь тийм ч таатай сонголт болоогүй гэдэг. Түүнчлэн, савхин өмдөөр ч тэд ижилсэж байсан удаатай.



Хамгийн түрүүнд бодолдоо дурлана...

Монголын зохиолчдын эвлэлийн гишүүн, сэтгүүлч, яруу найрагч У.Баярсайханы "Хамгийн түрүүнд бодолдоо дурлана" яруу найргийн ном, Монголын урчуудын эвлэлийн гишүүн, зураач Г.Цэнгүүнжавын "Ур" уран зургийн үзэсгэлэнгийн нээлт болох гэж байна. Энэхүү арга хэмжээ нь яруу найрагч, зураач хоёр хамтарч ажиллан шинэ бүтээл гаргаж буйгаараа онцлогтой ажээ. У.Баярсайханы 10 шүлгийн зургийг уран зураач Г.Цэнгүүнжав зурсан аж. Сэтгүүлч, яруу найрагч У.Баярсайхан 2009 онд "Бөгтөр сарны гэгээ", 2010 онд "Хүү нь тандаа" нийтийн дууны цомог, "Их л холын амраг" нийтийн дууны тоглолтыг Монгол бөхийн өргөөнд хийж, 2014 онд "Танихгүй танил" шигшмэл ярилцлагын номоо хэвлүүлж байсан. Харин түүний энэ удаагийн "Хамгийн түрүүнд бодолдоо дурлана" ном нь түүний яруу найргийн хоёр дахь бүтээл юм байна. Зураач Г.Цэнгүүнжав нь 1987 оноос олон улсад болон эх орондоо уран бүтээлийн 10 гаруй үзэсгэлэн гаргажээ. Уран бүтээлчдийн хамтарсан ном болон уран зургийн үзэсгэлэнгийн нээлт энэ сарын 15-нд Чин Ван Ханддоржийн өргөөнд болох юм байна.

2016.8.26

Аадар багын анд Шөнгөлийнхээ дудлагаар Дархан хотыг зорино. Гөвчтэнд Пантуг гэх түүний ооригчэн найз нь эцгийнх нь остонтой хуйвалдан урхи бэлдсэн байв. Аадарын эцэг хазгар Чука Мандалнарт эртний тооцоо байсныг Пантуг өөрт ашигтайгаар эргүүлж найзгаа золиосолж орхино. Пантугын балгаар хайртай бүсгүй дөнгөж мэндэлсэн бяцхан охиноосоо хагацсан Аадар ч бас ор сураггүй алга болно. Зургаан жилийн дараа гэнэт гарч ирсэн Аадар чухам юу хийж хэрхэх бол? Төр амьдралаа эргүүлэн авч чадах болов уу?

Еврейн нолоотойг бүлээ гаралтай Бен-Хур-аас ромын иргэн хамгийн сайн найз нь урваж боол болгоно. Оргож эх орондоо ирээд өшөөгөө авна.

Хөмөдөх сүүлийн 15 жил 23 ажлаас халагджээ. Мул нь тэр цахилгааны инженер болох хүсэлтэй ч хувь тавилан тэргийг хааш нь ч хамаагүй аваад шидчихдэг гэхэд болно. Сүүлийн удаа тэр ажлаасаа халагдсанаа эхнэртээ хэлсэнгүй тас нуужээ..